

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА


Т. Дөлгөөн

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн

Сонгосон орнууд

- Монгол
 - Гол худалдааны түншүүд: БНХАУ, ОХУ
 - Уул уурхайн салбарын голлох бүтээгдэхүүн: зэс, нүүрс
- Казакстан
 - Далайд гарцгүй хамгийн том нутаг дэвсгэртэй улс
 - Гадаад эрэлт: БНХАУ, ОХУ
- Перу
 - Зэсийн тэргүүлэгч үйлдвэрлэгчдийн нэг
 - Сүүлийн жилүүдэд ГШХО-ын дэмжлэгтэй эдийн засгийн өсөлт хурдсаж байгаа
- Замби
 - Далайд гарцгүй
 - Эдийн засаг зэсийн үнээс хамааралтай


ГШХО цэвэр урсгал, тэрбум ам.доллар, 1992-2017



Эх сурвалж: UNCTAD

Бизнес эрхлэхүй

Бизнес эрхлэхүй индекс, 2016 - 2019



Эх сурвалж: Дэлхийн банк

- 2016-2019 онд Монгол, Перугийн оноо нэмэгдсэн боловч, байр эрс ухарсан

Авлигын төсөөллийн индекс

Авлигын төсөөллийн индекс

		Казакстан	Монгол	Перу	Замби
Байр	2018 (180 орноос)	124	93	105	105
	2017 (180 орноос)	122	103	96	96
	2016 (176 орноос)	131	87	101	87
Оноо	2018	31	37	35	35
	2017	31	36	37	37
	2016	29	38	35	38


Эх сурвалж: Transparency International

- Казакстан: 2015 оны 1-р сард Эрүүгийн хуулиа чангатгасан
- Монгол: 2017 оны 7-р сард шинэ эрүүгийн хууль хэрэгжиж эхэлсэн, Авлигатай тэмцэх газар авлигын эсрэг үйл ажиллагаа явуулдаг
- Перу: 2016 онд өмнөх ерөнхийлөгч авлигын хэргээр баривчлагдсан
- Замби: Авлигатай тэмцэх арга хэмжээнүүд авч байгаа хэдий ч авлига өндөр хэвээр

Хөрөнгө оруулалтын таатай орчны индекс

- Хөрөнгө оруулалтын шийдвэрийн 60%-ийг бүс нутгийн геологи, уул уурхайн нөөц тодорхойлдог
- Бусад 40% нь бодлогын хүчин зүйлсээс шалтгаалдаг

Ашигт малтмалын потенциалын индекс (MPI)



Эх сурвалж: Fraser Institute

Хөрөнгө оруулалтын таатай орчны индекс

- Казакстан: Эрхзүйн систем сайжирсан, хууль, дүрэм журмын хэрэгжилтийн болон захиргааны тодорхой бус байдал буурсан
- Монгол: Геологийн мэдээллийн сан, хөдөлмөрийн нийлүүлэлт, үр чадвар сайжирч, тусгай хамгаалалттай газар нутагтай холбоотой тодорхой бус байдал буурсан
- Перу: Хөдөлмөрийн нийлүүлэлт, үр чадвар сайжирсан, орон нутгийн хөгжил болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой гэрээ, зохицуулалт сайжирсан.
- Замби: Татварын дэглэм, геологийн мэдээллийн сан болон улс төрийн тогтвортой байдлын талаарх тодорхой бус байдал нэмэгдсэн


Бодлогын төсөөллийн болон Хөрөнгө оруулалтын таатай орчны индекс

			Казакстан	Монгол	Перу	Замби
Бодлогын төсөөллийн индекс	Байр	2017 (91 улсаас)	59	70	43	71
		2016 (104 улсаас)	90	101	54	43
	Оноо	2017	61	54	69	53
		2016	39	28	70	74
ХО-ын таатай орчны индекс	Байр	2017 (91 улсаас)	24	53	19	58
		2016 (104 улсаас)	73	81	28	30
	Оноо	2017	71	61	74	59
		2016	54	49	73	73

Эх сурвалж: Fraser Institute

Монгол

- 2018 онд гадаадын хөрөнгө оруулалтын 90% нь Оюу толгой зэрэг томоохон уурхайд орсон
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл борлуулсны орлогод 30% татвар (2017.11.10)
 - Татварын суурийг шууд бус аргуудаар тооцно
 - Тусгай зөвшөөрөл шилжүүлбэл уг орд дээрх төслийн үнэлгээний 30%-тай тэнцүү татвар төлнө



Эх сурвалж: UNCTAD болон Дэлхийн банк

Казакстан

- 2016 онд ГШХО өссөн нь Шеврон зэрэг хөрөнгө оруулагчид Тэнгиз ордод 36.8 тэрбум ам.долларын хөрөнгө оруулсантай холбоотой
- 2018 оны 6-р сард Уул уурхайн шинэ хууль хэрэгжиж эхэлсэн ба тус хууль нь лиценз олгох үйл явцыг хялбаршуулах замаар гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилготой
- Уул уурхайн шинэ лиценз олголтыг сэргээсэн, хөрөнгө оруулалтын гэрээнүүдээс “орон нутгийн шинжтэй шаардлага”-ыг хассан

Казакстаны ГШХО ба газрын тосны үнэ




Эх сурвалж: UNCTAD and World Bank

Перу

- Уул уурхайн салбар экспортын голлох хувийг эзэлдэг ч олон нийтийн зүгээс эсэргүүцэл ихтэй
 - Шинэ уул уурхайн төслүүд байгаль орчны болон иргэний хөдөлгөөнүүдийн зүгээс хүчтэй эсэргүүцэлтэй тулгардаг
 - Хэрэгжиж буй томоохон төслүүд ч иргэний хөдөлгөөнүүдийн эсэргүүцлээс болж цуцлагдах эрсдэлтэй
 - Гадаадын эзэмшилтэй уул уурхайд иргэд илүү дургүйцэх хандлагатай


Перу: ГШХО ба зэсийн үнэ



Эх сурвалж: UNCTAD, Дэлхийн банк

Замби

- 2014 оноос хойш ашигт малтмалын үнийн өөрчлөлттэй холбоотойгоор нөөц ашигласны татвараа (роялти) хэд хэдэн удаа өөрчилсөн.
- Одоогийн зэсийн роялти:
 - Зэсийн үнэ 4500 ам.доллар/тн-оос бага бол 6%
 - 4500-6000 ам.доллар/тн бол 7%
 - 6000-7500 ам.доллар/тн бол 8%
 - 7500 ам.доллар/тн-оос их бол 10%



Source: UNCTAD, Дэлхийн банк

Санал, зөвлөмж

- Тогтвортой орчин
 - Институцийн болон бизнесийн орчин тогтвортой байх буюу хууль журмуудыг ойр ойрхон өөрчилдөггүй байх
 - Урт хугацааны хөрөнгө оруулалтын гэрээнд тогтворжуулалтын заалтууд оруулах
- Уул уурхайгаас бусад салбараа хөгжүүлэхэд анхаарах
 - ГШХО татах хамгийн их боломжтой салбаруудаа тодруулах, эрэмбэлэх
 - Жишээ нь: хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр (мах, ноолуур...)
- “Нэг цэгийн үйлчилгээ”
 - Зөвхөн уул уурхай гэлтгүй бүх салбарт хөрөнгө оруулах гадаадын бизнес эрхлэгчдэд бичиг баримт бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл авахад нь туслалцаа үзүүлэх
 - Үйлчилгээг цахимаар болон биечлэн авах боломжтой байх
- Ил тод байдал
 - Хөрөнгө оруулалтын гэрээнүүдийг ил тод болгох (Оюу толгойн гэрээ, зарим уурхайн орон нутагтай байгуулсан гэрээнээс бусад нь хаалттай)
 - Хөрөнгө оруулалтын гэрээ хэлэлцээрийн явцад орон нутаг, иргэдийн оролцоог хангах

Анхаарал хандуулсанд баярлалаа !